



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/56

Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсэг, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 2.4, 2.5-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ёс зүйн дэд хорооны ажиллах журам батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг 7 гишүүнтэй байхаар тогтоож, яамны албан хаагчдын санал хураалтын дүнг үндэслэн Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсугай.

2. Дэд хорооны даргыг хорооны хурлаар хэлэлцэж, сонгохыг дэд хорооны гишүүдэд даалгасугай.

3. Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг хуульд заасан харьяаллын дагуу шалган шийдвэрлэж, журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг Ёс зүйн дэд хороонд үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (С.Эрдэнэтуяа)-т даалгасугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Төрийн нарийн бичгийн даргын А/131 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА



Д.ОЧИРБАТ

142240448

Төрийн нарийн бичгийн даргын  
2024 оны 05 дугаар сарын 28 -ны  
едрийн 157 дугаар тушаалын хэвсгалт



Эрүүл мэндийн яамны Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн

- Э.Цэрэнчунт  
ЭМЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн Яамны хууль зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн;
- Б.Пүрэвжав  
ЭМЯ-ны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын Эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдлын хэлтэс Лавлагаа шатлалын тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн;
- Л.Лувсан  
ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн газрын дарга;
- С.Энхжин  
ЭМЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Нийтийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах шинжээч;
- Б.Оролзодмаа  
ЭМЯ-ны Нийтийн эрүүл мэндийн газрын Халдварт бус өвчний хэлтсийн Нөхөн үржихүй, эрэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн;
- Г.Түвшинбаяр  
ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын Стратеги удирдлагын хэлтсийн Салбарын хууль эрх зүйн шинэчлэлийн судалгаа, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн;
- М.Хулан  
ЭМЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт хариуцсан мэргэжилтэн